



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/44

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Оросын хамтарсан 3 дугаар сургуулийн өмчид холбогдох баримт бичигт дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ахлагч:	Д.Нарангэрэл /Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга/
Гишүүд:	Т.Б.Данзанов /ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны нэгдүгээр нарийн бичгийн дарга /зөвшилцсөнөөр/
	В.В.Белозеров /Холбооны улсын үйлдвэрийн “Хилийн чанад дахь төрийн өмчийг удирдах үйлдвэрийн газар” ФГУП “Госзагрансобственность” алс Дорнодын бүс нутгийн улс орнуудын төлөөлөгчийн газрын төлөөлөгч /зөвшилцсөнөөр/
	Г.Д.Зубович /ОХУ-ын Боловсролын яамны Олон улсын хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах газрын хоёр болон олон талт олон улсын хамтын ажиллагааны газрын дарга /зөвшилцсөнөөр/
	Ш.Нарантуяа /Боловсрол, шинжлэх ухааны яамны Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын дарга /зөвшилцсөнөөр/

132013564

Н.Нарангэрэл /Боловсрол, шинжлэх ухааны яамны
Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч
/зөвшилцсөнөөр/

С.Нансалмаа /Боловсрол, шинжлэх ухааны яамны
Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
/зөвшилцсөнөөр/

С.Сүхболд /Олон Улсын гэрээ, эрх зүйн газрын
захирал /зөвшилцсөнөөр/

А.Баярсайхан /Олон Улсын гэрээ, эрх зүйн
газрын атташе /зөвшилцсөнөөр/


Нарийн бичиг:

М.Баярмаа /Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын Төрийн
өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн
мэргэжилтэн/

2.Ажлын хэсгийн удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Удирдамжийн дагуу баримт бичигт дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргаж, тайланг танилцуулахыг Ажлын хэсэг (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 01 дугаар сарын 24 өдрийн
4/4 дугаар тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Монгол Оросын хамтарсан 3 дугаар сургуулийн өмчид холбогдох баримт бичигт дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг ОХУ-ын талтай хамтран ажиллаж, дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

1. Монгол Оросын хамтарсан 3 дугаар сургуулийн үл хөдлөх хөрөнгийн бодит байдалд үзлэг шалгалт хийж, холбогдох баримт бичигтэй танилцан дүн шинжилгээ хийнэ. /фото зураг, видео бичлэг хийх/
2. Эдэлбэр газар, кадастрын зургийн тулгалт хийх, маргаан гарсан тохиолдолд эргэлтийн цэгийн хэмжилт хийнэ.
3. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн шалгалт хийсэн тайланг боловсруулан хамтарсан Ажлын хэсгийн хуралдаанд танилцуулахад бэлтгэнэ.

-----000-----